

**“ТЭЭВЭР АЧЛАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03-р сарын 28-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

*Компанийн хэлбэр, нэрийг өөрчлөн хязгаарлагдмал  
хариуцлагатай компани болгох тухай*

“Тээвэр Ачлал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн Тогтоох нь:

1. “Тээвэр Ачлал” ХК-ийн хэлбэр, нэрийг өөрчлөн “Тринити энд Ко” ХХК болгох төслийг 01 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанийг өөрчлөн байгуулахтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журамыг 02 дугаар хавсралтаар баталсугай.
3. Компанийн хөрөнгийн үнэлгээг хийсэн хараат бус үнэлгээний “Лэндс үнэлгээ” ХХК-ийн хөрөнгийн үнэлгээг 03 дугаар хавсралтаар баталсугай.
4. “Лэндс үнэлгээ” ХХК-ийн гаргасан үнэлгээг үндэслэн нэгж хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг 15866 /Арван таван мянган найман зуун жаран зургаан / төгрөгөөр тогтоосугай.
5. “Тринити энд Ко” ХХК-ийн дүрмийн төслийг 04 дүгээр хавсралтаар баталсугай.
6. Компанийн хэлбэр, нэрийг өөрчлөн байгуулах төслийг хэрэгжүүлэх үүргийг Гүйцэтгэх захирал /Б.Түвшин /-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТЗОРИГ

**“ТЭЭВЭР АЧЛАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03-р сарын 28-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

*ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 61.1.9 болон 63 дүгээр зүйлийн 63,5 дахь заалт, Тооллогын комиссын 1, 2, 3 дугаар саналын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон 2025 оны бизнес үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
4. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлт болон холбогдох тайлангуудыг компанийн цахим хуудсандаа тогтмол байршуулж байлгах, цаашид компанийн үйл ажиллагааг сайжруулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Түвшин /-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТЗОРИГ

**“ТЭЭВЭР АЧЛАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03-р сарын 28-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

*ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай*

“Тээвэр Ачлал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн Тогтоох нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн болон хараат бус гишүүдийг дараахь бүрэлдэхүүнээр сонгосугай.

Ердийн гишүүдэд:

1. Б.Батзориг
2. Б.Түвшин
3. Л.Отгонжаргал
4. Б.Түшиг
5. Б.Бадамсүрэн
6. Э.Эрдэнэ-Очир

Хараат бус гишүүдэд:

1. Л.Гантуяа
2. Ц.Сайнжаргал
3. С.Энхтүвшин

2. Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн гишүүдийг томилон ажлуулах, цалин урамшууллыг нэг гишүүний 750,000 /долоон зуун тавин мянган/ төгрөгөөр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТЗОРИГ